**МОНГОЛ УЛС**
**ДУНДГОВЬ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН**
**ЗАХИРАМЖ**

2019 оны 09 сарын 11 өдөр Дугаар А/316 Мандалговь

Цэргийн бэлтгэл сургалтад аймаг, сумдын
Засаг даргын Тамгын газрын дарга нарыг
оролцуулах тухай

Монгол Улсын "Батлан хамгаалах тухай хууль"-ийн 15 дугаар зүйлийн 3.9, 17 дугаар зүйлийн 1.2, "Цэргийн албаны тухай хууль"-ийн 33 дугаар зүйлийн 10, Засгийн газрын 2018 оны 376 дугаар тогтоолоор баталсан "Аюулгүй байдал, батлан хамгаалах асуудлаар төрийн захиргааны төв болон нутгийн захиргааны байгууллага, аж ахуйн нэгж, байгууллагын удирдах бүрэлдэхүүнтэй сургалт, дадлага явуулах журам"-ын 3.4, Сангийн сайдын 2018 оны 318 дугаар тушаалаар баталсан "Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, зарцуулалтын нийтлэг журам"-ын 2.1.3 дахь заалт, аймгийн Засаг даргын 2019 оны 7 дугаар сарын 29-ний өдрийн 11 дүгээр хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

Нэг. Аймаг, сумдын Засаг даргын Тамгын газрын дарга нарын "Цэргийн бэлтгэл сургалт"-ыг 2019 оны 9 дүгээр сарын 23-наас 25-ны өдрүүдэд (Адаацаг сум Сүм Хөх бүрдэд) Монгол Улсын "Төрийн нууцын тухай хууль", Зэвсэгт хүчний нууцыг хадгалж, хамгаалах журамд заасны дагуу нууцлалын горимыг чанд сахин хөтөлбөр, төлөвлөгөөний дагуу чанартай, осол авааргүй явуулахыг Цэргийн штабын дарга (дэд хурандаа Ш.Гансүх)-д даалгасугай.

Хоёр. Тус арга хэмжээнд шаардагдах 2,936,600 (хоёр сая есөн зуун гучин зургаан мянга зургаан зуу) төгрөгийг аймгийн Засаг даргын нөөц хөрөнгөөс гаргаж зарцуулахыг аймгийн Засаг даргын Тамгын газрын дарга (Ц.Эрдэнэсүрэн) нягтлан бодогч (Д.Нандинцэцэг)-д зөвшөөрсүгэй.

ЗАСАГ ДАРГА О.БАТ-ЭРДЭНЭ

48819:916

Аймгийн Засаг даргын 2019 оны 09 дүгээр сарын
11..-ний өдрийн А/316 дугаар захирамжийн хавсралт

## А. БИЧИГ ХЭРЭГСЛИЙН ЗАРДАЛ

| № | Хэрэгслийн нэр | Үнэ (төгрөгөөр) | Тоо | Мөнгөн дүн (төгрөгөөр) | Тайлбар |
|---|---|---|---|---|---|
| 1 | Хичээлийн дэвтэр | 6,000 | 25 | 150,000 | |
| 2 | Үзэг бал | 3,500 | 25 | 87,500 | |
| 3 | Сертификат | 2,000 | 20 | 40,000 | |
| 4 | Жааз | 6,500 | 20 | 130,000 | |
| 5 | Хулдаасан хэвлэл (4*3) | 6,500 | 12м2 | 78,000 | |
| 6 | Маркер | 1,000 | 3 | 3,000 | |
| 7 | Самбарын алчуур | 1,500 | 1 | 1,500 | |
| **БҮГД** | | 490,000 | | | |

## Б. ТЭЭВРИЙН ЗАРДАЛ

| д/д | Автомашины марк | Замын урт (км) | Зарцуулагдах ШТМ (литр) | Нэг бүрийн үнэ (төгрөгөөр) | Мөнгөн дүн (төгрөгөөр) |
|---|---|---|---|---|---|
| 1 | УАЗ пургон | 160 | 29 | 1810 | 52,490 |
| 2 | УАЗ пургон | 160 | 29 | 1810 | 52,490 |
| 3 | Ланд 200 | 160 | 32 | 1910 | 61,120 |
| **БҮГД** | | | | 166,100 | |

## В. БАЙР, ХООЛНЫ ЗАРДАЛ. "СҮМ ХӨХ БҮРД" ЖУУЛЧНЫ БААЗ

| д/д | | Хэмжих нэгж) | Тоо | Нэгжийн үнэ (төгрөгөөр | Мөнгөн дүн (төгрөгөөр) |
|---|---|---|---|---|---|
| 1 | Гэр буудал | хоногоор | 5 х (2 өдөр) | 50,000 | 500,000 |
| 2 | Нэг өдрийн хоол | хоногоор | 25 хүн х (2 өдөр) | 21,000 | 1,050,000 |
| 3 | Чихэр, печень | (кг) | 5 | 15,000 | 75,000 |
| 4 | Ус, Ундаа | ширхэг | 120 | 1000 | 120,000 |
| 5 | Кофе, цай | боодол | 2 | 25,000 | 50,000 |
| 6 | Ааруул | кг | 5 | 30,000 | 150,000 |
| 7 | Айраг | литр | 65 | 3,500 | 227,500 |
| 8 | Жимс | Холимог кг | | | 100,000 |
| 7 | Нэг удаагийн аяга | ширхэг | 100 | 80 | 8,000 |
| **БҮГД** | | | | 2,280,500 | |

## Г. НЭГДСЭН ДҮН

| Бичиг хэргийн зардал | Тээврийн зардал | Байр хоолны зардал |
|---|---|---|
| 490,000 | 166,100 | 2,280,500 |
| 2,936,600 төгрөг | | |